



МИК ХОЛДИНГ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20²⁶ оны 3 сарын 11 өдөр

№ 26/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2026 оны 2 дугаартай дүгнэлт, Монгол Улсын Хөгжлийн банкны 2025 оны 2/1163 дугаартай албан бичгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах ердийн гишүүн Б.Сайнзаяаг 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөр тасалбар болгон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолын 1-т заасантай холбогдуулан чөлөөлөгдсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдээр “Ди Би Эм ассет менежмент” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Тэмүүжинг 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн Б.Сайнзаяагийн хэрэгжээгүй үлдсэн бүрэн эрхийн хугацаагаар томилсугай.
3. Л.Тэмүүжин нь энэ тогтоолын 2-т заасан бүрэн эрхийн хугацаанд ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж, Б.Сайнзаяагийн гишүүнчлэл бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны бүрэлдэхүүнд орж ажиллахыг дурдсугай.
4. Л.Тэмүүжинтэй “Нууц үл задруулах гэрээ” байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Хашчулуун)-д даалгасугай.
5. Л.Тэмүүжингийн бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн холбогдох журмын дагуу батлагдсан төсвийн хүрээнд цалинг тооцож олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
6. Энэ тогтоолд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх холбогдох хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар зохих хууль тогтоомжид заасан журмын дагуу хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэл хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба (Г.Саруул)-нд даалгасугай.
7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (Ч.Хашчулуун)-нд даалгасугай.



★